БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНБОЛД

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилт:** Авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлыг нэн тэргүүнд удирдах ажилтнуудын ёс зүй, үлгэр жишээч байдлаар манлайлах замаар хэрэгжүүлэх

2015.01.25 Арвайхээр

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| **Нэг. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт** | | | | |
| 1. | 1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м// | 1.1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.1.2 Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран Авлигын эсрэг сургалт, мэдээллийг булан ажлуулж, мэдээлэл, сургалталчилгааг үе шаттай зохион байгуулах | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.1.3 Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх, аль болох олон сувгаас мэдээлэл олж авах боломжийг орон нутагт бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ тогтмолжуулж, мэдээлэл сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1-12 сард | Н.Гоомарал<br>А.Отгонцэцэг |
| | | 1.1.4 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх урлагийн тоглолт, спорт өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах | 5, 12 сард | Ц.Пунцаг<br>Арвайхээр сумын ЗДТГ |
| | | 1.1.5 Төрийн байгууллагуудын мэдээллийн самбарыг иргэдэд ойлгомжтой, ил тод байлгах талаар зөвлөмж гаргаж хүргүүлэх, /бичиглэл нь харагдахуйц том, харааны түвшинд байрлуулах, мэдээлэл нь шинэ, хэрэгцээтэй мэдээлэл байх, мэдээллийг | 2 сард | Ч.Батсуурь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байнга шинэчилж байх зэрэг/ мэдээллийн самбарын хүртээмж, ач холбогдлыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | |
| 2. | 1.2 Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох | 1.2.1 Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийн /Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр, 2016 онд бэлтгэх модны тоо хэмжээ батлах, PC тоглоом ажлуулах журам, Авлигын эсрэг аймгийн страги төлөвлөгөө, байгалт орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ажил, 2016 оны төсвийн тодотгол, хүүхэд хамгааллын аймгийн бодлогыг хэрэгжүүлэх, эмнэлэгийн тусламжийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах, орон нутгийн авто замын сан, хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжүүлэх гэх мэт/ төслүүдийн талаар иргэд, олон нийтээс санал хүлээж авах, тусгах эргэж мэдээлэх үйл ажиллагааг тогтмолжуулах /цахим хуудас, санал асуулга, саналын хайрцаг, утсаар авч, эргэж мэдээлдэг болох/ хариуцсан албан тушаалтнуудын АБТ, үр дүнгийн гэрээнд тусгуулах | 4 удаа | Д.Мөнхцэцэг<br>Ч.Батсуурь |
| | | 1.2.2 УИХ-аар батлагдах зарим хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сумдын иргэний танхимуудаар нээлттэйгээр санал авах хайрцаг ажиллуулах, хэлэлцүүлэг хийх, аян гэх мэт ажлыг зохион байгуулах | Тухай бүр | Ц.Пунцаг<br>Хариуцсан албан тушаалтнууд |
| | | 1.2.3 Орон нутгийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах хэлэлцүүлэг, мэдээллийг ажлыг хэрэгжүүлэх | 3-6 сард | Ж.Мягмар |
| | | 1.2.4 Аймгийн Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах | 1-12 сард | Д.Мөнхцэцэг<br>Л.Долгормаа |
| | | 1.2.5 Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа тогмол байршуулах | 1-12 сард | Ч.Батсуурь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.2.6 Аймгийн ИТХурал, Засаг даргаас 2016 онд хэлэлцүүлж, гаргахаар шийдвэрлэсэн бодлогын баримт бичигт олон нийтийн саналыг тусгахаар хэлэлцүүлэг, уулзалтыг иргэд, олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж, бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх | 2-12 сард | Д.Мөнхцэцэг |
| 3. | 1.3 Байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, үр дүнг нээлттэй мэдээлэх | 1.3.1 Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг гарган, хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт шалгалтын талаарх мэдээлэл, төлөвлөгөө байгууллагын цахим хуудсанд байршуулж хэвших | 2-12 сард | Б.Бундмаа<br>Э.Бадамгэрэл<br>Ё.Сүхбаатар |
| | | 1.3.2 Байгууллага, сумдад хийгдэж байгаа хяналт шалгалтыг иргэдийн санал гомдалд үндэслэн явуулах, дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлж, иргэдийн зүгээс хяналт тавих боломжийг хангах | 1-12 сард | Н.Энхцэцэг<br>Ё.Сүхбаатар |
| | | 1.3.3 Аудитын газраас явуулсан хяналт, шалгалтын мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, байгуулагын цахим хуудсанд нээлттэй байршуулах | Тухай бүр | Д.Нэмэхбаяр<br>Ч.Батсуурь |
| | | 1.3.4 Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хийсэн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг албан хаагч, иргэд, олон нийтэд ил тод болгох | Тухай бүр | Б.Бундмаа |
| | | 1.3.5Оны эцэст сум, байгууллагуудын авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, түүний талаар иргэд, олон нийтийн саналыг авч, индексээр жагсаах, үүнийг сумын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулах, ХШҮнэлгээний мөрөөр зөвлөмж хүргүүлэх | 11 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.3.6 Шилэн дансны хуулиар хүлээсэн төсөв, санхүүгийн мэдээллийг цахимд байршуулах үүргийн биелэлтийг хянан шалгах ажлыг АТГ, эрх бүхий байгууллагатай хамтран, ИНБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх чиглэлээр санаачлага гарган хэрэгжүүлэх | 2, 11 сард | Ц.Ганболд<br>Д.Нэмэхбаяр |
| 4. | 1.4Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон | 1.4.1 Тухайн жилийн төсөв */1-р сарын 10-ны дотор/*, өмнөх оны төсвийн гүйцэтгэл */4 дүгээр сарын 1-ний дотор/*, дараа жилийн төсвийн төсөл */8 дугаар сарын 15-ны дотор/*-ийг цахим хуудсанд байршуулах | 1-8 дугаар сард | Ч.Болормаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нийтэд тухай бүр мэдээлэх | 1.4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах мөн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танилцуулах ажлыг тогтмолжуулах | 05 сарын 1-ний дотор | Ч.Болормаа<br>Ё.Сүхбаатар |
| | | 1.4.3Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах | өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт | Ж.Мягмар |
| | | 1.4.4 Төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/ | 1-12 сард | Л.Ламаачин |
| | | 1.4.5 Сарын төсвийн гүйцэтгэл, улирлын төсвийн гүйцэтгэл, хагас жилийн төсвийн гүйцэтгэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авчб хэрэгжүүлсэн арга хэмжээ төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны талаарх авч хэрэгжүүлсний арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, энэ тухай мэдээллийг тухай олон нийтэд мэдээлж хэвших | 1-12 сард | Д.Нэмэхбаяр<br>Ж.Мягмар<br>Л.Ламаачин |
| | | 1.4.6 Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт<br>цалингийн зардлаас бусад 5 сая төгрөөс дээш .....<br>байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт<br>НДС-аас тэтгэвэр тэтгэмж ... зэргийг тухай бүр хариуцсан албан тушаалтнуудаас мэдээллийг шинэчлэн гаргуулж, сайтад байршуулж байх | 1-12 сард | Ч.Батсуурь<br>Н.Гоомарал |
| | | 1.4.7 Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх | 1-12 дугаар сард | Ж.Мягмар |
| | | 1.4.8 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй | 1-12 дугаар | П.Мөнхзул |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хүргэх, цахим хуудсанд байршуулж хэвших | сард | |
| | | 1.4.9 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж сурталчлах, хяналт тавих | 2 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.4.10 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт тавих иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд мэдээллийг байгууллагын цахим хаяг, мэдээллийн самбар, олон нийт хурал, сурталчилгааны өдөрлөг зохион байгуулж түгээх | 3 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.4.11 ЖДҮД сан, сум хөгжүүлэх сан зэрэг улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа зээл, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зарцуулалтад ТББ, иргэдийн оролцоотой мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, хариуцлага тооцож ажиллах | 6-11 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.4.12 Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх | Тухай бүр | Ж.Бадамгарав |
| | | 1.4.13 Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаара-хаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх, цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Тухай бүр | Ж.Бадамгарав |
| 5. | 1.5 Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | 1.5.1 Засаг даргаас олгож буй тусгай зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам, зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд байршуулах | 1-12 сард | Д.Мөнхцэцэг<br>Р.Наранцэцэг<br>С.Долгорсүрэн |
| | | 1.5.2 Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаар улирал тутам хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх | 1-12 сард | Д.Мөнхцэцэг<br>Р.Наранцэцэг<br>С.Долгорсүрэн |
| | | 1.5.3 Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах /хууль тогтоомжид | 1-12 сард | Ц.Удвал<br>Ч.Батсуурь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/ | | |
| 6. | 1.6 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | 1.6.1 Төрийн албаны сул орон тооны зарыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах, сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах | Тухай бүр | Э.Бадамгэрэл |
| | | 1.6.2 Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх | 1-12 сард | Э.Бадамгэрэл |
| | | 1.6.3 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нээлттэй болгох, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулах | 1-12 сард | Э.Бадамгэрэл |
| 7. | 1.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | 1.7.1 Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг журмын хүрээнд үргэлжлүүлэх, ХАА-ы журам, холбогдох бусад мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод болгох, үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулах | 1-12 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.7.2 Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нээлттэй мэдээлэх /тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, урилгыг байршуулах ажил/ | 1-12 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.7.3 Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн хаягийг цахим хуудсандаа байршуулах | 1-12 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.7.4 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, бусад хяналт шалгалтын дүнг мэдээлэх ажлыг тогтмолжуулах | 1-12 сард | Ж.Бадамгарав |
| | | 1.7.5 Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, ТББ-ын төлөөллийг оролцуулсан байх | 1-12 сард | Ж.Бадамгарав |
| 8. | 1.8 Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх | 1.8.1 Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох | 1-12 сард | Э.Бадамгэрэл |
| | | 1.8.2 Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээний төлөвлөлт, ажил үүргийн хуваарийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, ил тод байршуулсан байдалд хяналт тавьж ажиллах | 1-3 сард | Н.Энхцэцэг<br>Ц.Удвал |
| 9. | 1.9 Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн | 1.9.1 Авлигатай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, хамтран ажиллах, тодорхой төрлийн чиг үүргийг | 5 сард | Ч.Батсуурь<br>А.Отгонцэцэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | гүйцэтгүүлэх | | |
| | | 1.9.2 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг шинэчлэн гаргаж, тэднээр гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлж, иргэд, иргэний нийгмийн байгууллагаас төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг өргөтгөх | 1-12 сард | Ц.Ганболд Ч.Батсуурь |
| | | 1.9.3. Дээрх төрийн бус байгууллагуудаа гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг иргэдэд нээлттэй мэдээлэх, гэрээ байгуулж ажиллах, хийсэн ажлын тайлан, хөндлөнгийн үнэлгээг эрх бүхий байгууллагад хүргүүлж хянуулах, мэдээлэх | 11-12 сард | Ч.Батсуурь |
| 10. | 1.10 Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх | 1.10.1 Шинээр томилогдсон эрх бүхийн албан тушаалтнуудыг сургалт хамруулах, томилсон шийдвэр, урамшуулал өгч байгаа эсэхэд шинэчилсэн судалгаа хийх | 10 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.10.2 Байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг шинэчлэн гаргаж, байгууллагуудад ажиллаж байгаа эрх бүхий албан тушаалтнуудын томилсон шийдвэр, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил үүргийн хуваарьт хяналт шинжилгээ үнэлгээ хийх | 10 сард | А.Отгонцэцэг Б.Бундмаа |
| 11. | 1.11 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | 1.11.1 Байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхижүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн тайлан, мэдээг АТГ-т хүргүүлэх | 1-12 сард | Н.Энхцэцэг |
| | | 1.11.2 Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлэх | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.11.3 Зөрчлийн талаар бүртгэл хөтлөх, зөрчил мэдээлэгчийн нууцлалыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, зөрчлийн талаарх мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлэх | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| | | 1.11.4 Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд тухайн албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, зөрчлийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг ажлыг тогтмолжуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| 12. | 12.1.Хууль болон Засгийн | 1.12.1 Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг судалж, | 5 сард | А.Отгонцэцэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх | шийдвэрлүүлэх, энэ чиглэлийн мэдээллийг төрийн албан хаагчдад өгөх ажлыг эрчимжүүлэх | | |
| | | 1.12.2 Давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх, журмыг биелүүлэх, албан тушаалтанд давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох | 1-12 сард | А.Отгонцэцэг |
| 13. | 13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ | 13.1.1 Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсан-даа байршуулах | 1-12 сард | Д.Мөнхцэцэг Л.Долгормаа |
| | | 13.1.2 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах | 1-12 сард | Ц.Удвал |
| | | 13.1.3 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | 1-12 сард | Ц.Удвал |
| 14. | 1.14 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | 1.14.1 Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах | 1-12 сард | Н.Энхцэцэг |
| | | 1.14.2 Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) | 1-12 сард | Н.Ширчин Л.Долгормаа |
| | | 1.14.3 Өргөдөл, гомдол, бичиг хэргийн асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | 1-12 сард | Н.Ширчин Л.Долгормаа |
| | | 1.14.4 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, шуурхай шийдвэрлэн, хариуг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх | 1-12 сард | Н.Ширчин Л.Долгормаа |
| | | 1.14.5 Сумдад газар эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлаар гаргасан иргэдийн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх талаар чиглэл өгч ажиллах | 1-12 сард | Н.Энхцэцэг Н.Ширчин |
| 15. | 1.15 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | 1.15.1 Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг шинэчилэн гаргаж, тэдгээрт чиглэсэн соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх | 1-12 сард | А.Отгонцэцэг Э.Бадамгэрэл |
| | | 1.15.2 Авлига болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой бодит | 1-12 | Ц.Ганболд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | мэдээллийг өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шалгаж, мэдээлдэг байх | сард | Ц.Пунцаг |
| | | 1.15.3 Авлигын эрсдэлд өртөж болзошгүй чиг үүрэг бүхий байгууллага, хэлтэс, агентлагуудад ТББ, иргэдийн оролцоотой үнэлгээ мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтэд эргэн хяналт тавих, хариуцлага тооцох, иргэдэд мэдээлэх | 10 сард | Ц.Пунцаг<br>Б.Бундмаа |
| | | 1.15.4 Төрийн албан хаагчдын хамаарал бүхий этгээдийн судалгаа, давхар ажил эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгөх, хяналт шалгалт зохион байгуулах | 5 сард | Ц.Пунцаг<br>Б.Бундмаа |
| | | 1.15.5. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг цахим сайт болон мэдээллийн самбар нээлттэй байршуулах | 1-12 сард | Ц.Удвал |
| 16. | 1.16 Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх | 1.16.1 Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаатай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас шалгуулахаар харъяаллын дагуу шилжүүлсэн өргөдөл гомдолд хяналт шалгалтыг зохион байгуулж, авсан арга хэмжээний талаар нийтэд мэдээлэх | 1-12 сард | Н.Энхцэцэг<br>Ц.Пунцаг |
| | | 1.16.2 АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэх | 1-12 сард | Ц.Пунцаг<br>А.Отгонцэцэг |
| 17. | 1.17. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | 1.17.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийг биелүүлэх, түүний үр дүнг тооцох, АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг хангах, зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг тооцох | 1-12 сард | Ц.Пунцаг<br>А.Отгонцэцэг |
| | | 1.17.2 АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийг биелүүлэх, зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг тооцох | 1-12 сард | Ц.Пунцаг<br>А.Отгонцэцэг |
| | | 1.17.3 АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг тооцох | 1-12 сард | Ц.Пунцаг<br>А.Отгонцэцэг |
| | | 1.17.4 АТГ-аас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн тохиолдолд байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох | 1-12 сард | А.Отгонцэцэг<br>Д.Мөнхцэцэг |
| | | 1.17.5 АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар | 1-12 сард | А.Отгонцэцэг<br>Ч.Батсуурь |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хүргэх арга хэмжээний журам"-ын биелэлтийг ханган ажиллах | | |
| **2. Авлигатай тэмцэх санал, санаачилга** | | | | |
| 18. | 2.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр төлөвлөж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2.2.1 Аймгийн ЗДТГазар, сум, агентлагуудын авлигын эсрэг 2016 авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тухайн байгууллагын албан хаагчид болон иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, төлөвлөгөөнд хагас жил тутам үнэлгээ хийж, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх | 2, 6, 11 сард | А.Отгонцэцэг |
| | | 2.2.2 Авлигын эсрэг 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг тухай бүр нь тооцож шийдвэрлэж байх. | Тухай бүр | Ц.Ганболд |
| | | 2.2.3 Орон нутаг дахь ТББ-уудыг чадавхижуулах ажлын АТГ-тай хамтран гурвалсан гэрээгээр хийх нөхцлийг судлах, тэднээр төлөвлөгөөг тогтмол үнэлүүлэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарим чиг үүргийг шилжүүлэх байдлаар дэмжих ажлыг зохион байгуулах | 2, 3 сард | Ц.Пунцаг |
| | | 2.2.4 АТГ-аас ирүүлсэн шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг ТАХ-дад зохион байгуулах мөн авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | 2,5 сард | Ц.Ганболд |
| 19. | 2.2Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | 2.2.1 Соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сум, байгууллагуудын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусган боловсруулах хэрэгжүүлэх | 1-2 сард | Ц.Ганболд |
| | | 2.2.2 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх, хамтран ажиллах | 1-12 сард | Н.Энхцэцэг |
| | | 2.2.3 Сум, байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд нь арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | 3 сард | Ц.Пунцаг |
| | | 2.2.4 Байгууллагын менежментийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн менежмент, харилцаа хандлагыг сайжруулах ажлыг зохион байгуулах | 3 сард | А.Отгонцэцэг |
| | | 2.2.5 Ажилтнуудын үйл ажиллагааг үнэлэх дүгнэх шалгуурт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга, ёс зүйтэй байдлын үнэлгээг тусган хэрэгжүүлэх | 2, 12 сард | Э.Бадамгэрэл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2.2.6 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг төрийн албан хаагчдын ёс зүй, шударга байдлыг дээшлүүлэх асуудалд чиглүүлж ажиллах | | Ц.Ганболд |
| 20. | 2.3. Албан хаагчдын шударга байдал ба шударга ёсны үнэлэмжийг нэмэгдүүлэх | 2.3.1 Албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх үйл ажиллагаануудыг тогтмолжуулах | 5 сард | А.Отгонцэцэг |
| | | 2.3.2 ЗДТГ, түүний хэлтэс, агентлаг бүр иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр теле-ярилцлага, семинар хэлэлцүүлэг зохион байгуулах | Тухай бүр | А.Отгонцэцэг |
| | | 2.3.3 Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчлийг шийдвэрлэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 1-12 сард | Ц.Пунцаг<br>Б.Бундмаа |
| | | 2.3.4 Байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчлийг шийдвэрлэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 1-12 сард | Н.Энхцэцэг |
| | | 2.3.5 Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчлийг шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч ажиллах | 1-12 сард | Ц.Пунцаг |
| | | 2.3.6 Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | 1-12 сард | Н.Энхцэцэг<br>Б.Нацаг |
| | | 2.3.7 Байгууллагын соёл, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтуудыг Тамгын газар болон бусад харьяа агенлагууд, холбогдох байгууллагуудад дотоодын нөөц бололцоогоор хийх боломжийг бүрдүүлэх, жилийн эцсийн ХШҮнэлгээгээр үр дүнг тооцох | 1-12 сард | Н.Энхцэцэг |
| | | 2.2.8 Байгууллага, албан тушаалтны ажлыг үнэлэхдээ иргэдийн оролцоог хангаж ажилласан байдлыг нэг үзүүлэлт болгон, дүгнэж байх | 1-12 сард | Э.Бадамгэрэл |

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**